



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 0257

Мандалговь

Шагналын журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Дундговь аймгийн Засаг даргын шагнал олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Урамшууллын жишиг тогтоох журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Дээрх журмуудыг байгууллага, иргэдэд сурталчлан хэрэгжүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, иргэдийн урлаг, спортын авьяасыг нээн илрүүлэх, сурагч, багш нарын оюуны хөдөлмөрийг бодитой дээшлүүлэх, тэдний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг бүх талаар дэмжин, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /О.Чулуунбат/, журамд заасан шагналд олгох мөнгөн хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж байхыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү журам гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/565 дугаар захирамж, Засаг даргын 2015 оны 09 сарын 18-ны өдрийн "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/370 тоот захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200714